



**ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 ОН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/35

Залаа

Г Стратеги төлөвлөгөө боловсруулах Г
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, “Төрийн албаны тухай хууль”-ийн 53 дүгээр зүйлийн 53.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалаар баталсан Стратеги төлөвлөгөөг боловсруулах аргачлал, загварын дагуу боловсруулсугай.

2. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Л.Батхуяг - Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга Б.Наранчулуун - Архив, бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд: Д.Дагважав - Санхүү албаны дарга

Ц.Хуяг - Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Б.Ганбат - Хөдөө аж ахуйн тасгийн дарга

У.Мөнхнаран - Газрын даамал

Ш.Бямбацогоо - Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Ш.Даваацэрэн - Сургуулийн захирал

Ш.Мөнхэрдэнэ - Соёлын төвийн эрхлэгч

Г.Энхбаяр - Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Б.Оюунчимэг - Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

3. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалын 1,2 дугаар хавсралт “Стратеги төлөвлөгөөг боловсруулах аргачлал загвар”-ын дагуу чанартай боловсруулан 03 дугаар сарын 20-ны дотор батлуулахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Батхуяг/-д үүрэг болгосугай.

2021058

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Н.Бямбадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Н.САЙХАНБАЯР

СУМЫН ЗАСАГ ДАРГА **БАТЛАВ** Н.САЙХАНБАЯР

2021 оны 02 сарын 15-ны өдөр



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2020-2024 он)**

АГУУЛГА

- 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....**
 - 2. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС**
 - 3. БАРИМТЛАХ ЗАРЧИМ.....**
 - 3.1 Алсын хараа**
 - 3.2 Эрхэм зорилго**
 - 3.3 Стратегийн зорилго**
 - 4. ЗОРИЛГО ЗОРИЛТУУД.....**
 - 4.1 Иргэдийн оролцоонд суурилсан ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх**
 - 4.2 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх**
 - 4.3 Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн цогц үйлчилгээ**
 - 4.4 Байгаль орчны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглаж, “Аялал жуулчлалын жишиг сум” болох**
 - 4.5 Төсөв санхүүгийн бодлого**
 - 4.6 Хөдөө аж ахуйн бодлого**
 - 4.7 Хууль эрх зүйн хэрэгжилт, нийгмийн аюулгүй байдлын бодлого**
 - 4.8 Батлан хамгаалах бодлого**
 - 4.9 Гадаад харилцааны бодлого**
 - 4.10 Тамгын газрын ажиллах нөхцөл, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийн бодлого**
 - 4.11 Дэд бүтэц, үйлдвэржүүлэлтийн бодлого, зорилтыг хэрэгжүүлж, Улсын тэргүүний сум болох**
 - 5. СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**
-

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засаг захиргаа, нутагт дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн бодлого боловсруулах, төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийхэд Засаг даргад туслах үүрэгтэй гэж тодорхойлсон. Энэхүү үүргийг хэрэгжүүлэхийн тулд тус сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албаны тухай хуулийн 13 дугаар бүлгийн 53 дугаар зүйлийн 1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагын 4 жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасны дагуу нийт ажилтан албан хаагчид үйл ажиллагаагаа нэгтгэн стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Монгол улсын Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 03 сарын 31-ний өдрийн 93 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.9 дугаар зүйлд заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын 2020-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газрын “Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө” нь дараахь зүйлүүдийг багтаасан болно.

- Тамгын газрын стратеги /алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зарчим, 2020-2024 онд дэвшүүлж буй стратегийн зорилтууд/
- Тухайн жилд сумын Засаг даргад Тамгын газраас нийлүүлэх бүтээгдэхүүний анги, түүний нэр төрөл, бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин
- Тамгын газрын боловсон хүчин, санхүү, материаллаг нөөцийн чадавхийг дээшлүүлэх, эд хөрөнгийг ашиглах хамгаалахтай холбогдсон зорилтууд
- Сумын үйл ажиллагааны төлөвлөгөө нь өмнөхөөсөө дараахь зүйлүүдийг илүү тодорхой болгосноороо ач холбогдолтой юм.

Үүнд: Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийн зорилттой уялдуулан бүтээгдэхүүнийг тодорхойлсон энэхүү төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон бүтээгдэхүүний мөн чанар нь байгууллагын үйл ажиллагааг чухал ач холбогдол бүхий ажил үйлчилгээнд төвлөрүүлэх боломж олгож байгаа бөгөөд энэ нь

сумын Засаг дарга, түүний Тамгын газраас дэвшүүлсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг хангахад бодитой хувь нэмэр оруулна.

Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны зарчим, стратегийн зорилт, хамрах хүрээ, зохион байгуулалтыг илүү тодорхой, цэгцтэй болгосон зэрэг болно. Үйл ажиллагааны энэхүү стратегийн төлөвлөгөө нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хангахад чиглэгдсэн бодлогын баримт бичиг тул түүний мөн чанар нь төрийн албан хаагчдын өдөр тутмын ажилд шууд мэдрэгдэхээсээ илүү зөв бодлого, хандлага чиглэл, сэтгэлгээ, удирдлага, зохион байгуулалт, арга барил, ур чадвар, үр дүнг бий болгоход оршино.

Стратеги төлөвлөгөөний зорилго зорилтуудыг Засгийн газрын бодлого төлөвлөлт болон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, ардчиллыг бэхжүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжлийг байгаль орчинтой уялдуулах, төрийн бодлогыг ил тод нээлттэй болгож, ард иргэдийн оролцоог хангах зэрэг ардчилсан төрийн тогтолцоог төлөвшүүлэх дэлхий нийтийн чиг хандлагатай нийцүүлж, цаг үеийн шаардлагаар дэвшигдэн гарч байгаа шинэ асуудлуудыг шийдвэрлэн, хэрэгжүүлэхийг зорьсон.

2. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

- Монгол улсын Үндсэн хууль
- Монгол улсын Засгийн газрын тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол улсын “Төсвийн тухай” хууль
- Монгол улсын “Төрийн албаны тухай” хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэл
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулах хүрээ түүнчлэн эрхзүйн үндэс болно.

3. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Чадахуйн зарчим /мерит/ буюу иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хуулиар тодорхойлж, мэдлэг, чадвартай иргэдэд нээлт *Карьерын шатлан дэвших тогтолцоо*-тэй өрсөлдөөнөөр төрийн албанд орох боломж олгохын зэрэгцээ төрийн албанд нэвтрүүлнэ.

Сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албанд мэдлэгтэй, чадвартай, хариуцлагатай, шударга, ил тод байдлыг хангасан сайн засаглалыг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа дараах зүйлийг эрхэмлэнэ.

Мэдлэг, чадвартай байх: Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх хангалттай мэдлэгийг эзэмшин, түүнийгээ цаг үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, төрийн бодлогын залгамж чанарыг хангаж, мэргэшсэн үйлчилгээ, дэмжлэгийг Засаг дарга, Тамгын газарт үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулна.

Хамтын ажиллагаа: Нэгдсэн зохион байгуулалтай, хөрвөх чадвартай мэргэшсэн, чадварлаг хамт олонд түшиглэсэн багийг бүрдүүлж ажиллана.

Хариуцлагатай байх: Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албаны манлайлал, үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, ажилдаа чин сэтгэлээсээ бүтээлч, санаачлагатай, хуулийг дээдлэн ажиллана.

Санаачилгатай, үргэлж сайжруулан, шинийг туршин нэвтрүүлж байх: Сумын Засаг даргын Тамгын газар нь өөрийн алсын хараагаар чиг баримжаа авч, үргэлж санаачилгатай, өөр дээрээ туршин үр дүнтэй нь нотлогдсон шинэ дэвшилтэт туршлагаар бусдыг үлгэрлэн дагуулж, түүнийг нийтийн хүртээл болгоно.

Үйлчилгээг хэрэглэгчдэд чиглүүлэх: Засаг даргын Тамгын газар нь үндсэн болон бусад хэрэглэгчээ тодорхойлж, тэдгээрийн хэрэгцээг танин мэдэрч, уг хэрэгцээг хангахад чиглэсэн хүний нөөцийн удирдлагатай холбогдсон улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан, зөвлөгөө өгөх, зохицуулалт хийх, тусгай үйлчилгээ үзүүлэх замаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг цаг ямагт дээшлүүлэх явдал юм.

Төсөвт байгууллага, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой улсын үйлдвэрийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм, сургалт судалгааны байгууллагатай түншлэлийн сайн харилцаа тогтоож, өөрийн үйл ажиллагаагаараа тэдний итгэл, хүндэтгэлийг хүлээж ажиллах болно.

Бүтээлч, ил тод, хууль дээдлэх: Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагч бүр хариуцсан ажилдаа бүтээлчээр хандаж, Төрийн албаны тухай хуулиар төрийн жинхэнэ албан тушаалд томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлан “Ил тод байх”, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх”, “Захирах, захирагдах ёсыг” баримтлан, зарчмыг мөрдөн, сайн засаглалыг нийгмийнхээ хэрэгцээ шаардлагатай уялдуулан асуудлаа хамт олноороо шийдвэрлэх үйл явц болно.

Ёс зүй, шударга, нээлттэй байх: Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан, соёлтой, шударга, ил тод нээлттэй байдлыг эрхэмлэн ажиллана.

Таатай орчинтой байх: Албан хаагчдын өсөн дэвжих боломжийг тэгш нээсэн чадахуйн зарчимд тулгуурлан шинэ санаа, шинэлэг арга барил, мэдлэг чадвараа тасралтгүй дээшлүүлж, түүнийг үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглах хандлага, санал, санаачилгыг хөхүүлэн дэмжсэн ажлын байрны таатай орчинг бүрдүүлнэ.

СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

3.1 АЛСЫН ХАРАА

“Хүний хөгжлийг дээдэлсэн төрийн цогц үйлчилгээтэй, уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлсэн, байгальд ээлтэй шинэ технологи бүхий үйлдвэр, дэд бүтэц, аялал жуулчлал хөгжсөн манлайлагч сум болох”

3.2 ЭРХЭМ ЗОРИЛГО

Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг чандлан баримталж, иргэдийн ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ хуулийн хүрээнд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

3.3 СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

3.3.1 Иргэдийн оролцоонд суурилсан ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

3.3.2 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх

3.3.3 Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн үйлчилгээ

3.3.4 Нийгмийн салбаруудын барилга байгууламжийг шинэчлэн, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж, эдийн засгийн өсөлт, орон нутгийн бие даасан байдлыг ханган, “Улсын тэргүүний сум” болох

3.3.5 Байгаль орчны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хэвээр хадгалах, байгалийн нөөц баялагаа хамгаалах, зүй зохистой ашиглаж, аялал жуулчлалын хөгжлөөр тэргүүлсэн жишиг сум болох

3.3.6 Төр засаг, аймаг, орон нутгийн бодлого шийдвэрийг сум орон нутагт хэрэгжүүлэх, малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах малчид иргэдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

4. ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

4.1 Иргэдийн оролцоонд суурилсан ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

4.1.1 Иргэд ба иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилсан засаглалыг төлөвшүүлэх, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлэх

4.1.2 Жендерийн тэгш байдлыг хангах

4.1.3 Ил тод байдал шударга ёсыг хөхүүлэн дэмжих

4.1.4 Хүнд суртал, авилгалгүй төрийн албатай орон нутгийн захиргааг төлөвшүүлэх

4.2 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх

4.2.1 Засаг даргын Тамгын газрын стратеги зорилт нь төлөвлөлт, үр дүнд суурилсан удирдах чадавхийг бэхжүүлэх

4.2.2 Хяналт, хариуцлагын зарчимд үндэслэсэн, хүнд суртал, авлигаас ангид иргэдэд нээлттэй, төрийн үйлчилгээг бий болгож, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

4.2.3 Бүх шатны төрийн албан хаагчдын ажил үүргийн давхардлыг арилгаж, сум, байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах

4.2.4 Хүний нөөцийн зохистой хөгжлийг хангах

4.2.5 Тамгын газрын үйл ажиллагааг цахимжуулах замаар төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээг төвлөрсөн цэгээс үйлчлэх цахим засаглалыг хөгжүүлэх

4.3 Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн цогц үйлчилгээ

4.3.1 Эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл, өвчлөл эндэгдлийг тууштай бууруулан, хүн амын цэвэр өсөлтийг ханган, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, стандартад нийцсэн оношлогоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх

4.3.2 Олон Улсын стандартад нийцсэн, үндэсний онцлогийг агуулсан боловсролыг эзэмшсэн, мэдлэг, мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлэн амьдрах чадвартай эх орны хөгжлийн ирээдүйн иргэнийг сургаж бэлтгэхэд анхаарч ажиллах

4.3.4 Хүн амын тогтвортой хөгжлийг хангахад нийгмийн хамгааллын цогц бодлогыг чиглүүлэн, нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт хүргэж амьдралын чанарыг сайжруулах, жендерийн тэгш байдлыг эрхэмлэн, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийг бүх талаар дэмжих

4.3.5 Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрх бүрийн хэрэгцээтэй уялдуулж ажлын байрыг өмнөх оныхоос 5 хувиас доошгүй ахиулах, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоог жил бүр 15 өрхөөр бууруулах

4.4 Байгаль орчны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглаж, аялал жуулчлалын жишиг сум болох

4.4.1 Иргэдийн байгаль орчны талаарх боловсролыг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлэхэд тэдний оролцоог нэмэгдүүлнэ.

4.4.2 Сумын нутаг дэвсгэрт ногдох орон нутгийн тусгай хамгаалалттай газрын талбайн хэмжээг нэмэгдүүлэх

4.4.3 Эхийн гол , ногоон цав, Хаан тоорой Зуун мод, түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, маршрут тогтоох

4.4.4 Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг байгаль орчин, хүний эрүүл мэндэд хоргүй хог хаягдлыг хаях, цуглуулах тогтолцоог сайжруулах

4.5.5 Сумын төвийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлж, цэвэрч, бүтээлч сум болох хөдөлгөөнийг өрнүүлж иргэдэд ээлтэй таатай амьдрах орчин бүрдүүлэх

4.5. Төр Засаг, аймаг, орон нутгийн бодлого шийдвэрийг сум орон нутагт хэрэгжүүлэх, малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах малчид иргэдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

4.5.1 Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малын генетик нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих

4.5.2 Мал аж ахуйн талаар төр засаг, аймаг орон нутгаас гарсан хууль, бодлого шийдвэр, шинжлэх ухаан технологийн сүүлийн үеийн ололт, цаг үеийн асуудлаар сургалт сурталчилгаа хийх

4.5.3 Мал аж ахуй эрхлэгчдийг сургах, дадлагажуулах, мэдээллээр хангах, малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг баримтжуулан бүртгэх, түгээн дэлгэрүүлэх

4.5.4 Мал амьтныг бүртгэлжүүлэх, хувийн дугаар гэрчилгээтэй болгох ажил үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлэх

4.5.5 Мал аж ахуйн ангилалт, хээлтүүлэгч бойжуулж бэлтгэх, гаднаас авах үржлийн цөм сүрэг бүрдүүлэх талаар малчдад ойлгуулсны үндсэн дээр сум хөгжүүлэх болон орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө төлөвлөж хэрэгжүүлэх

4.5.6 Малын генетик нөөц, удам зүй, ашиг шимийн талаарх мэдээллүүдийг нэгтгэн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах, малчид иргэдэд таниулах сурталчилах

4.5.7 Бог малын хээлтүүлэгчийг ялган суурьлах, ашиглуулах, мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтанд оруулах ажлыг удирдан зохион байгуулах

4.5.8 Малын удам гарваль, ашиг шимийн талаар тодорхойлолт гаргах түүнд үндэслэн гэрчилгээ олгох

4.5.9 Мал сүргийг эрсдэлээс хамгаалах, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах, малын хариулга маллагаа тэжээлэг зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн ажил үйлчилгээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зохион байгуулж хэрэгжүүлэх

4.5.10 Эрчимжсэн болон туслах аж ахуй хөгжүүлэх, цэвэр үүлдрийн болон эрлийз малын бүртгэл судалгаа хийх

4.5.11 Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд шинжлэх ухааны сүүлийн үеийн арга технологийн талаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт явуулах

4.5.12 Тариаланчдыг бүртгэлжүүлж, ургамалын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, гэрчилгээ олгох асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх

4.5.13 Газар тариалангийн үйлдвэрлэлтэй холбоотой төсөл хөтөлбөрийг сумын хэмжээнд зохион байгуулах

4.6 Төсөв санхүүгийн бодлого:

4.6.1 Нээлттэй, ил тод, иргэдийн оролцоотой, хариуцлагатай төсвийн орчинг бүрдүүлж төсөв, санхүүгийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх

4.6.2 Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, татварын суурийг өргөжүүлэн, татварт хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр бодит өөрчлөлт хийж, татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, сэтгэлгээний хандлагыг өөрчлөх

4.6.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцогчдод тэгш боломж олгох, ил тод хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэн, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх замаар төсвийн хөрөнгийн эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх

4.6.4 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах

4.7 Хууль эрх зүйн хэрэгжилт, нийгмийн аюулгүй байдлын бодлого:

4.7.1 Хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчинг бүрдүүлэх

4.7.2 Хууль, эрх зүйн салбарын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлж, аливаа хууль зөрчсөн үйлдэлтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх

4.7.3 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, иргэд аюулгүй орчинд тайван амьдрах баталгааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг орон нутгийн эрх мэдлийн түвшинд зохион байгуулах

4.7.4 Төрийн архивын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, албан хэрэг хөтлөлтийн ажлыг шинэ шатанд гаргах

4.8 Батлан хамгаалах бодлого

4.8.1 Батлан хамгаалах нь бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан иргэдийн алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлж, иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах

4.9 Гадаад харилцааны бодлого:

4.9.1 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад харилцааны бодлого, үйл ажиллагаа үр өгөөжтэй, нэгдмэл байх зарчмыг хэрэгжүүлэх

4.10 Тамгын газрын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийн бодлого

4.10.1 Сумын удирдлагын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад эрүүл ахуйн болон ариун цэвэр, техникийн нөхцөл бололцоогоор бүрэн хангаж, дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний ажилчдын чадавхийг дээшлүүлэх, ажилчдыг шинэ ширээ сандал, техник хэрэгслээр бүрэн хангах, байгууллагын цэвэрч байдал, үйлчилгээний соёлыг байнга дээшлүүлэх

4.10.2 Тамгын газрын хурлын заал, гараж, спорт заал фитнес танхим, амралтын өрөө болон бусад өмч хөрөнгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, байгууллагад мөрдөхөөр гаргасан журмын хэрэгжилтийг хангах, өмч хөрөнгөнд хяналт тавьж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, санхүүгийн ажлыг тогтмолжуулж, тайлан баланс хугацаанд нь гаргах

4.10.3 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцон, ажилчдын эрүүл мэндэд анхаарч, ажиллах нөхцөл бололцоог байнга нэмэгдүүлнэ.

4.10.4 Хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж, чадахуйн зарчимд тулгуурлан боловсон хүчнийг томилж, мэдлэг чадварыг байнга нэмэгдүүлнэ.

4.11 Дэд бүтэц, үйлдвэржүүлэлтийн бодлого, зорилтыг хэрэгжүүлж, Улсын тэргүүний сум болох

4.11.1 Нийгмийн салбаруудын барилга, байгууламжийг шинэчлэн, үйлдвэрлэл үйлчилгээг өргөжүүлэх

4.11.2 Бүтээн байгуулалтын ажлын тоог нэмэгдүүлж, салбар тус бүрээр гүйцэтгэн хэрэгжүүлэх, архи худалдан борлуулах цэгийг бууруулах.

4.11.3 Сум орон нутгийн онцлогт нийцүүлэн үйлдвэр, үйлчилгээний тоог нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх

4.11.4 Багуудыг үүрэн телефоны сүлжээний станцтай болгох

4.11.5 Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор төрийн албан хаагчдыг орон сууцжуулах

5. СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1 Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн тайлантай хамтатган хийнэ.

5.2 Баримт бичигт тусгагдсан стратегийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- ✓ Тамгын газрын ажилд тавих хяналт, менежмент сайжирна.
- ✓ Төрийн албаны үйл ажиллагаа нээлттэй, үр дүнд суурилж, үйлчилгээнд чиглэгдэн үр ашиг нэмэгдэнэ.
- ✓ Тамгын газрын ажилтнуудын ажлын уялдаа холбоо сайжирч, удирдлагын хувьд дотоод хяналтад анхаарал тавих боломж бүрдэнэ.
- ✓ Тамгын газрын зохицуулах үүргээс олон нийтийн оролцоонд тулгуурласан бодлого боловсруулах үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн байгууллага болно.
- ✓ Төсвийн болон үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хэвшүүлнэ.
- ✓ Тамгын газрын нэр хүнд дээшилж олон нийтийн зүгээс хүлээх итгэл нэмэгдэнэ.

Байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Баянлиг сумын свот (SWOT) шинжилгээ, ерөнхий шинжилгээг хийн, харуулвал:

А. Давуу тал:

- Өрх, хүн амын дундаж өсөлт сайн
 - Бүтээлч, авьяаслаг, хөдөлмөрч иргэдтэй
 - Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар олон
 - Байгалийн ашигт малтмал, эрдэс баялгийн нөөцтэй
 - Харзтай, Хөмсөгийн рашаантай
 - Байгалиа унаган төрхөөр нь хадгалсан
-

- Газрын хөрс цэвдэггүй
- Эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан
- Ямаан сүргийн тоогоор аймаг улсад-р байранд ордог
- Боловсон хүчний нөөц хангалттай
- Интернет болон үүрэн холбооны сүлжээнд холбогдсон
- Төвлөрсөн зах зээлд ойр
- Төрийн үйлчилгээний хүртээмж дээшилсэн

Б. Сул тал:

- Зам бартаа ихтэй
- Ажилгүйдэл, ядуурал их
- Дэд бүтэц муу хөгжсөн
- Мал сүргийг эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцөл боломж муу
- Төсвийн зардлын багахан хувийг орон нутгаас бүрдүүлдэг
- Бэлчээрийн даац хэтэрсэн
- Төрийн албан хаагчдын нийгмийн хамгаалал хангалтгүй

В. Боломж:

- Улс, аймгийн жишиг сум болох
- Сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг хөгжүүлэх
- Гадаад харилцааг хөгжүүлэх
- Байгаль орчин, Аялал жуулчлал хөгжүүлэх
- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх
- Ахуйн үйлчилгээг өргөжүүлэх
- Байгаль орчинд ээлтэй Уул уурхайг хөгжүүлэх
- Орон сууцны хороолол барих
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, өрхийн орлогыг нэмэгдүүлэх
- Сумын хот байгуулалтыг урд, хойд, зүүн зүгрүүгээ тэлж, хүн амын суурьшлыг нэмэгдүүлэн, шилжилт хөдөлгөөнийг багасгах
- Мал аж ахуй, “Шинэ хот айл”, Газар тариалангийн салбарыг /шилдэг тариаланч/ бодлогод тулгуурлан хөгжүүлэх

Д. Бэрхшээл, эрсдэл:

- Ган, зуд, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртсон.
 - Цөлжилт их явагдаж байгаа.
 - Малын гаралтай түүхий эд сумд бүрэн төвлөрдөггүй
 - Томоохон бизнес эрхлэх санхүүгийн чадавхи хангалтгүй
 - Хортон мэрэгчид ихэссэн
 - Ахуйн түймэр гарах
-

- Хур тундас орохгүй
- Шороон шуурга их шуурдаг
- Хүн малын халдварт өвчин
Ногоо муутайгаас болж сэг зэм их
- Булаг шанд багассан
- Ядуурал, ажилгүйдэл ихсэх

Сумын Засаг даргын Тамгын газрын орчны шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> ○ Тамгын газар мэргэшсэн, чадварлаг хамт олон бүрдсэн. ○ Нэгдсэн халаалтын шугам сүлжээ, цэвэр, бохир усны шугаманд холбогдсон. ○ Хөдөөгийн иргэдтэй харилцаа холбоогоор холбогдох, мэдээлэл өгөх бүрэн боломжтой. ○ Өндөр хурдны интернетийн сүлжээнд холбогдсон. ○ Иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний хүртэмж дээшилсэн. ○ Байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан. ○ Төрийн албан хаагчид нь тогтвор суурьшилтай ажилладаг. ○ Багаар ажиллах чадвар сайжран харилцан мэдээллээ солилцдог. 	<ul style="list-style-type: none"> ○ Албан хаагч нар илүү цагаар ажилладаг боловч цалин урамшуулал олгодоггүй. ○ Ажилтан, албан хаагчдыг гадаад, дотоодод сайн туршлага судлуулах боломж нөхцөл муутай. ○ Үйл ажиллагаа явуулахад төсөв санхүүгийн хүрэлцээ дутмаг ○ Ажилчдын цалин хөлс бага, өрхийн хэрэгцээг бүрэн хангадаггүй. ○ Компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүрэн шийдэгдээгүй ○ Нутгийн удирдлагын ордон хуучин өрөө тасалгаа хангалтгүй , ○
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> ○ Бодлого боловсруулах түвшинд мэргэшсэн хамт олон багаар ажиллах боломжтой ○ Олон нийтийн хэлэлцүүлэг, фокус бүлгийн уулзалт, санал асуулга зохион байгуулах ○ Мэдээлэл түгээн сурталчлах, эргэх холбоо бий болгох ○ Шийдвэр гаргах түвшинд асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэхэд мэдээллийн техник технологи бүрдсэн. ○ Ажилчдын орон сууцтай болох ○ Улс, аймгийн жишиг сум болох ○ Жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> ○ Дээд газраас хуваарилсан төсөв санхүү нь дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаа явуулахад хүрэлцдэггүй учир өр авлага үүсч төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг. ○ Татварын орлогын төлөвлөгөө өндөр төлөвлөгддөг. ○ Үйлчилгээ эрхлэхэд төвлөрсөн зах зээлд ойрхон

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ

